

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ

/Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Засгийн газрын /цаашид “Засгийн газар” гэх/ үйл ажиллагааны зарчим, нийтлэг чиг үүрэг, бүрэн эрх, бүтэц, бүрэлдэхүүн, Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудал, ажлын зохион байгуулалт, түүнчлэн Засгийн газраас бусад байгууллагатай харилцан ажиллах журмыг тогтоож, зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл.Засгийн газрын тухай хууль тогтоомж**

2.1.Засгийн газрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### **3 дугаар зүйл.Засгийн газар, түүний чиг үүрэг**

3.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлд заасан ёсоор Засгийн газар нь Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

3.2.Засгийн газар Монгол Улсын хуулийг биелүүлж, эдийн засаг, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

##### **4 дүгээр зүйл.Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам**

4.1.Засгийн газрыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 97, 101 дүгээр зүйлд заасан үндэслэл, журмын дагуу эмхлэн байгуулна.

4.2.Ерөнхий сайдыг огцруулах, шинээр томилох, чөлөөлөх болон Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Дөчин гуравдугаар зүйл, Дөчин дөрөвдүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 17 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 97-100 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

## **5 дугаар зүйл.Засгийн газрын үйл ажиллагааны зарчим**

5.1.Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.

5.2.Засгийн газар нь асуудлыг хамтран хэлэлцэж олонхын санаа бодолд түшиглэн цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж шийдвэрлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг дангаар хариуцах, үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хариуцлага хүлээх, нутаг дэвсгэрийн болон салбарын удирдлагын зарчмыг хослуулах үндсэн дээр ажиллана.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХ**

### **6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрхийн үндэс, хугацаа**

6.1.Засгийн газар нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд энэ хууль, бусад хуульд заасан тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.2.Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлд зааснаар 4 жил байна.

6.3.Засгийн газар бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө огцорсон тохиолдолд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

6.4.Засгийн газар огцорсон тохиолдолд шинэ Ерөнхий сайдыг томилох хүртэл тухайн Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

### **7 дугаар зүйл.Хуулийн биелэлтийг хангах**

7.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах арга замыг тодорхойлон уул ажлыг нэгтгэн удирдах;

7.1.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж, биелэлтийг хангах;

7.1.3.төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

7.1.4.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, үйлдвэрийн газарт хянан шалгаж, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцэх;

7.1.5.хувийн өмчийн хуулийн этгээд, төрийн бус байгууллага хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих;

7.1.6.шаардлагатай бол хувийн өмчийн хуулийн этгээд, төрийн бус байгууллагын удирдлагын хүсэлтийг үндэслэн тэдгээрийн мэдээллийг хэлэлцэх;

7.1.7.хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл, сургалт, хууль тогтоомж тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулах;

7.1.8.хууль тогтоомжийн биелэлтийн талаар Улсын Их Хуралд тогтмол мэдээлэх.

## **8 дугаар зүйл.Нийгэм, эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогыг удирдах**

8.1.Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

8.1.2.улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

8.1.3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсвийн биелэлтийг хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулах;

8.1.4.эдийн засгийн харилцааг өмчийн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авах;

8.1.5.Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8.1.6.улсын хэмжээнд баримтлах шинжлэх ухаан, технологийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.7.үндэсний баялаг, төрийн өмчийг хамгаалах арга хэмжээ авч, хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулах.

## **9 дүгээр зүйл.Хүн амын нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх**

9.1.Нийгмийн хөгжил болон хүн амын нийгмийн хамгааллын талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.соёл, урлагийг өмчийн олон хэлбэрт түшиглэн хөгжүүлэх бодлого, түүний эдийн засаг, эрх зүйн баталгааг хангах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.2.монголын ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, уламжлалт зан заншил, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9.1.3.бүх шатны боловсролын тогтолцоо, насан туршийн суралцахуй, тэгш хамрах боломжийг хөгжүүлэх хөтөлбөр, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.4.хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд улс, төрийн бус байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулах;

9.1.5.хүн амын бодлого, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар төрөөс баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.6.хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн асуудлаар оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, иргэдийн хөдөлмөр, ахуй, орон сууцны нөхцөл, амьдралын чанарыг сайжруулах, хэрэглэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

9.1.7.гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн халамж, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эх нялхас, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах.

## **10 дугаар зүйл.Салбар, салбар хоорондын болон бүс нутгийн хөгжлийг хангах**

10.1.Салбар, салбар хоорондын болон бүс нутгийн хөгжлийг хангах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоон хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

10.1.2.эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд эдийн засгийн салбаруудын хүч чармайлтыг нэгтгэн чиглүүлж, салбар хоорондын харилцан ажиллагааг зохицуулах;

10.1.3.аймаг, бүс нутгийн хөгжлийг хангах, тэдгээрийн хооронд эдийн засгийн зөв зохистой хэлхээ холбоо тогтоон бэхжүүлэх нийтлэг зарчим, загвар боловсруулан хэрэгжүүлж, энэ талаар нутгийн захиргааны байгууллагуудад шаардлагатай туслалцаа үзүүлэх;

10.1.4.орон нутгийн байгууллага, хуулийн этгээдийн бие даасан байдлыг улс орны хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын нийтлэг ашиг сонирхолтой уялдуулан зохицуулах.

## **11 дүгээр зүйл.Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах**

11.1.Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.байгаль, орчныг хамгаалах эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, энэ хүрээн дэх Засгийн газрын болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн үйл ажиллагааг зохицуулах;

11.1.2.байгалийн баялгийг судалж нөөцийн хэмжээ, эдийн засгийн нэгдсэн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шүтэлцээг хангах нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

11.1.3.байгалийн тэнцвэрт байдлын хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох;

11.1.4.гамшиг осол, орчны ноцтой бохирдолоос сэргийлэх, учирсан хор уршгийг арилгахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах;

11.1.5.газар, түүний хэвлий, гадаргын болон гүний ус, ойн сан, агаар мандал, ургамал, амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

11.1.6.улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горим, дурсгалт болон нөөц газрын хилийн зааг, хамгаалалтын горим тогтоож, биелэлтийг нь зохион байгуулах.

## **12 дугаар зүйл.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдах**

12.1.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.төрийн албыг мэргэшсэн, чадварлаг, цомхон, боловсронгуй байх шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, энэ талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

12.1.2.төрийн албан хаагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

12.1.3.захиргааны хяналт, удирдлагын хүрээн дэх хяналт шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулах;

12.1.4.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тогтоон, тэдгээрийн орон тооны болон зардлын төсвийн хязгаарыг баталж, зохих шатны удирдах албан тушаалтныг томилж, чөлөөлөх;

12.1.5.төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын болон тэдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг хөгжлийн бодлогын зорилтод чиглүүлэн зохицуулах;

12.1.6.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын болон арга зүйн туслалцаа үзүүлж, тэдгээрийн бие даасан ажиллагааг хангах арга хэмжээ авах;

12.1.7.аймаг, нийслэлийн Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, шаардлагатай бол өөрийн тодорхой бүрэн эрхэд хамаарах тухайлсан асуудлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлэх.

### **13 дугаар зүйл.Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах**

13.1.Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.үндэсний аюулгүй байдлыг хангах болон улсын батлан хамгаалах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

13.1.2.зэвсэгт хүчнийг хөгжүүлэх арга хэмжээ авах;

13.1.3.орон нутгийн хамгаалалт, дайчилгааны тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх арга хэмжээ авах;

13.1.4.улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдах;

13.1.5.үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

13.1.6.үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалахад зайлшгүй шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авах;

13.1.7.төрийн болон албаны нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдах;

13.1.8.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, онцгой ажиллагааг удирдан чиглүүлэх.

#### **14 дүгээр зүйл.Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах**

14.1.Хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.хүний эрх, эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авах;

14.1.2.хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

14.1.3.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар төрийн бус байгууллага, иргэний нийгэм, олон улсын байгууллагатай хамтарч ажиллах;

14.1.4.төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг нэгтгэн удирдах;

14.1.5.хүн амд үзүүлэх хууль зүй, төрийн үйлчилгээг зохион байгуулах;

14.1.6.төрийн удирдлагын хүрээн дэх мэдээллийн албыг зохион байгуулж, хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэх;

14.1.7.нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

#### **15 дугаар зүйл.Төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх**

15.1.Төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн талаар төрийн гадаад бодлого боловсруулж хэрэгжүүлэх, гадаадын бодлогын нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах;

15.1.2.гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

15.1.3.Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрыг Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийг үндэслэн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэж, тэдгээр байгууллагын бүтэц, дүрэм, орон тооны хязгаарыг баталж, ажилтны цалингийн дундаж нэгжийг тогтоох;

15.1.4.Монгол Улсаас гадаад улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэд суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

15.1.5.гадаад улс, олон улсын байгууллагад суух Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлыг шийдвэрлэх;

15.1.6.Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад өөрийн эрх хэмжээний дотор Монгол Улсыг төлөөлөх;

15.1.7.дээд, өндөр түвшний айлчлал, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх.

## **16 дугаар зүйл.Олон улсын гэрээ байгуулах**

16.1.Олон улсын гэрээ байгуулах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1.заавал соёрхон батлах хоёр талт олон улсын гэрээ байгуулах, хоёр болон олон талт олон улсын гэрээг соёрхон батлах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

16.1.2.өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын, эсхүл Засгийн газар хоорондын хоёр талт олон улсын гэрээ байгуулах, олон талт олон улсын гэрээг батлах, цуцлах асуудлыг шийдвэрлэх;

16.1.3.заавал соёрхон батлах шаардлагагүй олон улсын гэрээг гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулах, цуцлах асуудлыг шийдвэрлэх;

16.1.4.хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох асуудлыг шийдвэрлэх;

16.1.5.Засгийн газар хоорондын олон улсын гэрээг өөрийн эрхлэх асуудлын хүрээнд байгуулах эрхийг төрийн захиргааны төв байгууллагад олгох;

16.1.6.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах;

16.1.7.төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, шүүх эрх мэдлийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулахад хууль тогтоомжид заасан тохиолдолд зөвшөөрөл олгох;

16.1.8.олон улсын гэрээнээс үүсэн гарсан асуудлаар Монгол Улсын эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗАР, ТҮҮНИЙ БҮТЭЦ**



## **17 дугаар зүйл.Засгийн газар**

17.1.Засгийн газар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс бүрдэнэ. Засгийн газрыг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлнэ.

17.2.Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Шадар сайд гүйцэтгэнэ. Ерөнхий сайд, Шадар сайд нэгэн зэрэг түр эзгүй байх тохиолдолд Ерөнхий сайдын үүрэг болгосноор Засгийн газрын аль нэг гишүүн Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэнэ.

17.3.Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ.

17.4.Засгийн газар үйл **ажиллагаагаа** танхимын зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ.

17.5.Танхимын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь Засгийн газрын хуралдаан байна.

17.6.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг Ерөнхий сайдын захирамжаар байгуулж болно.

17.7.Энэ хуулийн 17.6-д заасан зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Засгийн газар тогтооно.

## **18 дугаар зүйл.Монгол Улсын яам**

18.1.Монгол Улсын яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн.

18.2.Монгол Улсын яамыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн, Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулж, татан буулгана.

18.3.Засгийн газрын бүтцэд доор дурдсан яам ажиллана:

18.3.1.Ерөнхий чиг үүргийн:

- 18.3.1.1.Батлан хамгаалах яам;
- 18.3.1.2.Гадаад харилцааны яам;
- 18.3.1.3.Сангийн яам;
- 18.3.1.4.Хууль зүй, дотоод хэргийн яам;
- 18.3.1.5.Эдийн засаг, хөгжлийн яам.

18.3.2.Чиглэлийн:

- 18.3.2.1.Байгаль орчин, аялал жуулчлалын яам;
- 18.3.2.2.Барилга, хот байгуулалтын яам;
- 18.3.2.3.Боловсрол, шинжлэх ухааны яам;
- 18.3.2.4.Зам, тээврийн хөгжлийн яам;
- 18.3.2.5.Соёлын яам;

- 18.3.2.6.Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам;
- 18.3.2.7.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам;
- 18.3.2.8.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- 18.3.2.9.Цахим хөгжил, харилцаа холбооны яам;
- 18.3.2.10.Эрчим хүчний яам;
- 18.3.2.11.Эрүүл мэндийн яам.

18.4.Монгол Улсын яамыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд тэргүүлнэ.

18.5.Сайд өөртөө хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд салбарын болон салбар хоорондын зохицуулалттай холбоотой асуудлаар тушаал гаргах эрхтэй.

18.6.Яам, харьяалах агентлаг, байгууллагын үйл ажиллагааг сайдын өмнө хариуцах үүрэг бүхий дэд сайд байна.

18.7.Монгол Улсын сайдын эрхлэх ажлын хүрээн дэх чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд сайдад зөвлөх үүрэгтэй сайдын зөвлөл ажиллана.

18.8.Сайдын зөвлөлийн ажиллах нийтлэг журам, орон тоо, зардлын хязгаарыг Засгийн газар тогтооно.

18.9.Монгол Улсын яам нь яамны аппаратын гүйцэтгэх ажлыг зохион байгуулан удирдаж, сайд үйл ажиллагаагаа шуурхай явуулахад шууд туслах үндсэн чиг үүрэгтэй Төрийн нарийн бичгийн даргатай байна.

18.10.Төрийн нарийн бичгийн дарга нь Монгол Улсын сайдаас өгсөн үүрэг даалгаврыг хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, шийдвэрт нийцүүлэн биелүүлнэ.

18.11.Төрийн нарийн бичгийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

18.12.Төрийн нарийн бичгийн даргыг улируулан томилж болно.

18.13.Төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон Төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацаа өмнөх Төрийн нарийн бичгийн даргын бүрэн эрхийн хугацааны үлдсэн хугацаатай адил байна.

18.14.Төрийн нарийн бичгийн дарга яамны дотоод ажил, боловсон хүчний томилгоо, төсвийн зарцуулалттай холбоотой асуудлаар эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангуулна.

18.15.Монгол Улсын яамны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

## **19 дүгээр зүйл.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, түүний удирдлага**

19.1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын Ажлын алба мөн.

19.2.Хэрэг эрхлэх газрыг Засгийн газрын гишүүн тэргүүлнэ.

19.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга газрынхаа үйл ажиллагааг удирдахын хамт Засгийн газрын гишүүний хувьд энэ хуулийн 23.8.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

19.4.Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдын өмнө ажлаа хариуцна.

19.5.Хэрэг эрхлэх газар энэ хуулийн 23.8.2 дахь заалт, 36 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

## **20 дугаар зүйл.Засгийн газрын агентлаг**

20.1.Засгийн газар нь үйл ажиллагааныхаа зохих хүрээ, салбарт тохируулах болон хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийг Улсын Их Хурлаас зөвшөөрсөн бүдүүвчийн дагуу байгуулан ажиллуулна.

20.2.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, эрхлэх асуудлынх нь хүрээнд тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 4 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

20.3.Агентлагийг татан буулгасан нь агентлагийн даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх үндэслэл болно. Агентлагийн даргыг улируулан томилж болно.

20.4.Агентлагийн даргын бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол дараагийн томилогдсон даргын бүрэн эрхийн хугацаа өмнөх даргын бүрэн эрхийн хугацааны үлдсэн хугацаатай адил байна.

20.5.Хуульд өөрөөр заагаагүй бол агентлаг нэгээс илүүгүй дэд даргатай байна.

20.6.Агентлагийн дэд даргыг хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн албаны тухай хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө.

20.7.Агентлагийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

## **21 дүгээр зүйл.Дэд сайдын бүрэн эрх**

21.1.Дэд сайд сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд харьяа агентлаг, байгууллагатай харилцах, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

21.1.2.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн шуурхай зохицуулалтыг хангуулах;

21.1.3.сайдын даалгаснаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргатай харилцах;

21.1.4.Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий сайдаас байгуулах хороо, комисс, зөвлөл, ажлын хэсэгт сайдын түр эзгүйд түүний даалгаснаар сайдыг төлөөлөх;

21.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.

21.2.Сайдын түр эзгүйд түүнийг орлож гаргасан шийдвэрээ сайдад танилцуулах бөгөөд уг шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна.

21.3.Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байна.

21.4.Дэд сайдын бүрэн эрхийн хугацаа нь түүнийг Ерөнхий сайд томилсноор эхэлж, тухайн дэд сайдыг шинээр томилсноор дуусгавар болно.

21.5.Дэд сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

21.6.Дэд сайдыг орон гарсан тохиолдолд Засгийн газар 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно. Нөхөн томилогдсон дэд сайдын бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

21.7.Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр огцорсон, Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг уг албан тушаалд дахин томилоход саад болохгүй.

21.8.Сайд хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн нас нөгчсөн нь албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн дэд сайдыг албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болохгүй.

21.9.Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ дэд сайд Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно.

21.10.Дэд сайд бодлогын асуудлаар сайдтай санал зөрснөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно. Харин энэ талаар эцсийн шийдвэр гартал үүрэгт ажлаа гүйцэтгэж, хариуцлагыг нь хүлээнэ.

## **22 дугаар зүйл.Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх**

22.1.Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлж болно.

22.2.Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, үүнтэй холбогдуулан улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна.

22.3.Энэ хуулийн 22.1-д заасны дагуу хариуцуулан гүйцэтгүүлэх чиг үүргийн хүрээ хязгаар, санжүүжилт олгох журмыг Засгийн газар тогтооно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮН**

### **23 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн**

23.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

23.2.Засгийн газрын гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн томилогдвол гишүүнийхээ бүрэн эрхийг хэвээр хадгална.

23.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.

23.4.Засгийн газрын гишүүн нь Монгол Улсын сайд байна.

23.5.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн болон тодорхой хүрээний ажил эрхэлнэ.

23.6.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын үндсэн асуудлыг энэ хуулиар, тодорхой ажлыг бусад хуулиар зохицуулна.

23.7.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд дараахь асуудал хамаарна:

23.7.1.төрийн өмчийн бодлого;

23.7.2.тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал;

23.7.3.төрийн тусгай хамгаалалтын асуудал;

23.7.4.нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;

23.7.5.мэргэжлийн спортын хөгжлийн асуудал;

23.7.6.жендэрийн хөгжлийн асуудал.

23.8.Засгийн газрын гишүүн доор дурдсан хүрээний асуудлын бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дотоод аудит, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

23.8.1.Монгол Улсын Шадар сайд:

23.8.1.1.гамшгаас хамгаалах асуудал;

23.8.1.2.хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал;

23.8.1.3.стандартчилал, хэмжил зүйн асуудал;

23.8.1.4.тохирлын үнэлгээний итгэмжлэлийн асуудал;

23.8.1.5.шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал;

23.8.1.6.хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;

23.8.1.7.тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;

23.8.1.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт.

23.8.2.Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:

23.8.2.1.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт;

23.8.2.2.Засгийн газрын дотоод мэдээлэл;

23.8.2.3.Засгийн газраас Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчтэй харилцах асуудал;

23.8.2.4.төрийн захиргааны төв байгууллагын шуурхай удирдлага, салбар хоорондын бодлого, зохицуулалтын уялдааг хангах асуудал;

23.8.2.5.нийслэл, орон нутгийн захиргааны байгууллагын удирдлага, зохицуулалт, бодлогын уялдаа холбоог хангах асуудал;

23.8.2.6.Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал;

23.8.2.7.иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх асуудал;

23.8.2.8.төрийн албаны хүний нөөцийн асуудал.

23.8.3.Батлан хамгаалахын сайд:

23.8.3.1.улсын батлан хамгаалах бодлого;

23.8.3.2.зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлого;

23.8.3.3.энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын цэргийн хамтарсан сургуульд оролцох бэлтгэл хангуулах асуудал;

23.8.3.4.зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, хамтын ажиллагааны асуудал;

23.8.3.5.орон нутгийн хамгаалалт, дайчилгааны асуудал.

23.8.4.Гадаад харилцааны сайд:

23.8.4.1.гадаад улс, олон улсын байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх;

23.8.4.2.гадаадад байгаа Монгол Улсын иргэн, Монгол Улсын бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;

23.8.4.3.олон улсын гэрээ байгуулах, олон улсын гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, байгууллага хоорондын гэрээ байгуулах явцад хяналт тавих асуудал;

23.8.4.4.гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээр харилцах, хамтын ажиллагаа;

23.8.4.5.дипломат, албан ангиллын виз, консулын асуудал.

23.8.4.6. бүс нутгийн интеграцийн бодлого, олон талт, бүс нутаг болон хоёр талын худалдаа, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээний асуудал;

23.8.4.7. төрийн захиргааны төв болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гадаад харилцааг уялдуулан зохицуулах, хяналт тавих асуудал.

#### 23.8.5. Сангийн сайд:

23.8.5.1. төсвийн бодлого, төсөв, санхүү, эдийн засгийн судалгаа, төсөөлөл;

23.8.5.2. төсвийн орлого, зарлага, мөнгөн болон санхүүгийн хөрөнгө, өрийн нэгдсэн удирдлага;

23.8.4.3. улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт, түүний зарцуулалтын хяналт;

23.8.4.4. зээл, тусламжийг хэрэгжүүлэх асуудал;

23.8.4.5. нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн үнэлгээний бодлого;

23.8.4.6. гаалийн бодлого;

23.8.4.7. татварын бодлого;

23.8.4.8. санхүүгийн зах зээл, даатгалын бодлого;

23.8.4.9. улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, санхүүжилтийн үйл ажиллагаа;

23.8.4.10. нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт, нэгдсэн төсвийг улсын хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулах асуудал;

23.8.4.11. төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын бодлого;

23.8.4.12. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны бодлого;

23.8.4.13. хилийн боомтыг хөгжүүлэх асуудал.

#### 23.8.6. Хууль зүй, дотоод хэргийн сайд:

23.8.6.1. хууль зүйн нэгдсэн бодлого, эрх зүйн шинэтгэл;

23.8.6.2. хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;

23.8.6.3. эрх зүйн туслалцаа;

23.8.6.4. улсын хил хамгаалал, хилээр шалган нэвтрүүлэх асуудал;

23.8.6.5. цагдаа, дотоодын цэрэг, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;

23.8.6.6. шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;

23.8.6.7. Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн сахилгын хороо, хууль, эрх зүйн чиглэлийн нийтийн эрх зүйн этгээдтэй харилцах асуудал;

23.8.6.8. иргэний харьяалал, цагаачлалын асуудал;

23.8.6.9.дипломат болон албан ангиллаас бусад виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;

23.8.6.10.төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;

23.8.6.11.иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;

23.8.6.12.оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;

23.8.6.13.архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төрөөс баримтлах бодлого;

23.8.6.14.шүүхийн шинжилгээний асуудал;

23.8.6.15.олон улсын арбитрын болон бусад маргаанд Засгийн газрыг төлөөлөх асуудал.

23.8.7.Эдийн засаг, хөгжлийн сайд:

23.8.7.1.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийг улс, салбар хоорондын болон бүс, орон нутгийн хэмжээнд нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, зээл, тусламжийн нэгдсэн бодлого;

23.8.7.2.макро эдийн засгийн бодлогын судалгаа, төлөвлөлт;

23.8.7.3.бүсчилсэн хөгжлийн бодлого;

23.8.7.4.эдийн засгийн болон хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох, төслүүдийн нэгдсэн бодлого;

23.8.7.5.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөлт;

23.8.7.6.эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, гадаад, дотоод худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;

23.8.7.7.хөнгөн, жижиг, дунд, хүнд болон аж үйлдвэрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;

23.8.7.8.концесс, төр-хувийн хэвшлийн түншлэлийн бодлого, төлөвлөлт;

23.8.7.9.өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцооны бодлого, төлөвлөлт;

23.8.7.10.чөлөөт бүс, хилийн боомтын хөгжлийн бодлого, төлөвлөлт;

23.8.7.11.хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах нэгдсэн бодлого;

23.8.7.12.хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлт.

23.8.8.Байгаль орчин, аялал жуулчлалын сайд:

23.8.8.1.ногоон хөгжлийн бодлого;

23.8.8.2.байгаль орчныг хамгаалах, нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;

23.8.8.3.аялал жуулчлалын бодлого;



23.8.8.4.газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын бодлого;

23.8.8.5.ойн болон усны сан бүхий газар, улсын тусгай хамгаалалттай газрыг хамгаалах, зохистой ашиглах асуудал;

23.8.8.6.усны нэгдсэн бодлого, усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, сав газрын менежмент, усны бохирдлыг бууруулах асуудал;

23.8.8.7.байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;

23.8.8.8.биоаюулгүй байдлын бодлогын асуудал;

23.8.8.9. биологийн олон янз байдлыг хамгаалах асуудал;

23.8.8.10.агаар, орчны бохирдлыг бууруулах бодлогын асуудал;

23.8.8.11.уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний бодлого.

23.8.9.Барилга, хот байгуулалтын сайд:

23.8.9.1.барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;

23.8.9.2.хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;

23.8.9.3.газрын харилцаа, газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн асуудал;

23.8.9.4.нийтийн аж ахуйн асуудал;

23.8.9.5.орон сууцны бодлого .

23.8.10.Боловсрол, шинжлэх ухааны сайд:

23.8.10.1.сургуулийн өмнөх, ерөнхий, мэргэжлийн болон дээд боловсролыг хөгжүүлэх бодлого, зохицуулалт;

23.8.10.2.насан туршийн суралцахуйн бодлого, зохицуулалт;

23.8.10.3.шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого;

23.8.10.4.боловсрол, шинжлэх ухааны талаарх олон улсын хамтын ажиллагааны бодлого, зохицуулалт;

23.8.10.5.өндөр технологи, инновацийг хөгжүүлэх асуудал;

23.8.10.6.цөмийн энергийн судалгаа, бодлого, зохицуулалт;

23.8.11.Зам, тээврийн хөгжлийн сайд:

23.8.11.1.авто замын бодлого, зохицуулалт;

23.8.11.2.автотээврийн бодлого, зохицуулалт;

23.8.11.3.төмөр зам, төмөр замын тээврийн бодлого, зохицуулалт;

23.8.11.4.иргэний нисэх, агаарын тээврийн бодлого, зохицуулалт;

23.8.11.5.далай ашиглах болон усан замын тээврийн бодлого, зохицуулалт;

23.8.11.6.тээврийн нэгдсэн тогтолцоо, тээвэр логистикийн бодлого, зохицуулалт.

23.8.12.Соёлын сайд:

23.8.12.1.соёл, урлагийг хөгжүүлэх бодлого;

23.8.12.2.гадаад сурталчилгааны бодлого, зохицуулалт;

23.8.12.3.түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;

23.8.12.4.ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого.

23.8.13.Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд:

23.8.13.1.эрдэс баялгийн бодлого;

23.8.13.2.геологийн судалгаа, эрэл, хайгуулын бодлого, зохицуулалт;

23.8.13.3.газрын тосны эрэл, хайгуул, олборлолт, ашиглалт, боловсруулалт, газрын тосны бүтээгдэхүүний нөөц, хангамж, хадгалалт, тээвэрлэлтийн талаарх бодлого, зохицуулалт;

23.8.13.4.цацраг идэвхт ашигт малтмал хайх, ашиглах бодлого, зохицуулалт;

23.8.13.5.ил тод, хариуцлагатай уул уурхайн бодлого, зохицуулалт;

23.8.13.6.хүнд үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлэх асуудал, үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал;

23.8.13.7.эрдэс баялаг болон хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;

23.8.14.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд:

23.8.14.1.хүн амын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх асуудал, зохицуулалт;

23.8.14.2.нийгмийн халамжийн бодлого;

23.8.14.3.нийгмийн даатгалын бодлого;

23.8.14.4.хүүхэд, залуучууд, ахмадын болон гэр бүлийн хөгжлийн асуудал;

23.8.14.5.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал;

23.8.14.6.хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;

23.8.14.7.хөдөлмөрийн нөхцөл, ажилтны цалин, амьдралын өртгийн талаарх асуудал;

23.8.14.8.хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, ажил олгогч, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;

23.8.14.9.хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт, ур чадварын болон богино хугацааны сургалтыг хөгжүүлэх асуудал;

23.8.14.10.хөдөлмөрийн биржийн асуудал;  
23.8.14.11.Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;

23.8.14.12.гадаадад ажиллах хүч гаргах асуудал.

23.8.15.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд:

23.8.15.1.хүн амын хүнсний хангамжийн бодлого, зохицуулалт;  
23.8.15.2.хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, зохицуулалт;  
23.8.15.3.мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого, зохицуулалт;  
23.8.15.4.газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого, зохицуулалт;

23.8.15.5.мал, амьтны эрүүл мэнд, малын генетик нөөцийг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, зохицуулалт;

23.8.15.6.мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;  
23.8.15.7.мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудал;

23.8.15.8.хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглах, хамгаалах бодлого;

23.8.15.9.малыг гамшиг, ослын эсрдэлээс хамгаалах асуудал;  
23.8.15.10.жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх асуудал;

23.8.15.11.хөнгөн үйлдвэрлэлийн бодлогыг хэрэгжүүлэх асуудал, үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал;

23.8.15.12.бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах бодлого, зохицуулалт;

23.8.15.13.дотоод худалдааны бодлогыг хэрэгжүүлэх асуудал;  
23.8.15.14.хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, зохицуулалт.

23.8.16.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд:

23.8.16.1.харилцаа холбоо, сансар, мэдээллийн технологи, өргөн нэвтрүүлэг, шуудангийн бодлого, зохицуулалт;

23.8.16.2.цахим засаглал, салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих асуудал;

23.8.16.3.радио давтамжийн бодлого;  
23.8.16.4.бүх нийтийн үйлчилгээний үүргийн талаарх бодлого, зохицуулалт;

23.8.16.5.нийтийн мэдээллийн дэд бүтцийн асуудал;  
23.8.16.6.харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын инновацыг хөгжүүлэх асуудал;

23.8.16.7.кибер аюулгүй байдлын бодлого, зохицуулалт;

23.8.16.8.цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах бодлого, зохицуулалт;

23.8.16.9.мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудал.

23.8.17.Эрчим хүчний сайд:

23.8.17.1.эрчим хүчний нэгдсэн бодлого;  
23.8.17.2.эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;

23.8.17.3.сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;  
23.8.17.4.эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого;

23.8.17.5.түлшний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт;

23.8.17.6.эрчим хүч хэмнэлтийн бодлого;

23.8.17.7.эрчим хүчний нүүрс хангамж, ашиглалтын асуудал.

23.8.18.Эрүүл мэндийн сайд:

23.8.18.1.хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, нөхөн сэргээх нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн бодлого;

23.8.18.2.эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалт, хангамж, эмийн үйлдвэрлэлийн талаарх бодлого;

23.8.18.3.эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;

23.8.18.4.эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийн бодлого, зохицуулалт.

23.9.Шадар сайдын түр эзгүйд түүний үүргийг Шадар сайдын саналыг үндэслэн Ерөнхий сайдын үүрэг болгосон Засгийн газрын аль нэг гишүүн гүйцэтгэх бөгөөд ийнхүү Шадар сайдын үүргийг гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн Ерөнхий сайдаас олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлага хүлээнэ.

## **24 дүгээр зүйл.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа**

24.1.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчдүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байх бөгөөд Улсын Их Хурлаас Ерөнхий сайдыг томилсноор эхэлж, шинэ Ерөнхий сайдыг томилсноор дуусгавар болно.

24.2.Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоолыг баталсан тохиолдолд Ерөнхий сайд огцорно.

24.3.Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

24.4.Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорсон бол дараагийн Ерөнхий сайд томилогдох хүртэл Засгийн газрын гишүүд үүрэгт ажлаа гүйцэтгэнэ.

24.5.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас чөлөөлөгдсөн, огцорсон, түүнчлэн нас нөгчсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно.

24.6.Ерөнхий сайд чөлөөлөгдсөн, огцорсон, нас нөгчсөн тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно.

24.7.Засгийн газрын гишүүний орон гарсан тохиолдолд Ерөнхий сайд түүнийг энэ хуулийн 26.1.2-т заасан журмын дагуу 14 хоногийн дотор нөхөн томилно.

24.8.Энэ хуулийн 24.7-д заасны дагуу нөхөн томилогдсон Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

24.9.Эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар Ерөнхий сайд албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсны улмаас чөлөөлөгдсөн, нас нөгчсөн бол Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг Шадар сайд гүйцэтгэнэ.

24.10.Засгийн газрын орон гарсан гишүүнийг нөхөн томилох хүртэл Ерөнхий сайд Засгийн газрын нэг гишүүнд түүний үүргийг хуваарилан хариуцуулж болно.

24.11.Бүрэлдэхүүнээрээ огцорсон явдал нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр дахин томилогдоход татгазах үндэслэл болохгүй.

## **25 дугаар зүйл.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх, огцрох үндэслэл**

25.1.Эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ Ерөнхий сайд Улсын Их Хуралд, Засгийн газрын гишүүн нь Ерөнхий сайдад тус тус өргөн мэдүүлнэ.

25.2.Засгийн газрын гишүүн өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний бодлогын асуудлаар Ерөнхий сайдтай, эсхүл гишүүдийн олонхтой санал зөрсөн зэргээс бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Ерөнхий сайдад хэдийд ч гаргаж болно.

25.3.Засгийн газрын гишүүнийг огцруулах тухай эцсийн шийдвэр гартал тухайн Засгийн газрын гишүүн үүрэгт ажлаа гүйцэтгэж, хариуцлагыг хүлээнэ.

## **26 дугаар зүйл.Ерөнхий сайдын бүрэн эрх**

26.1.Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцаж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон тэдгээрт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд Ерөнхийлөгчтэй зөвшилцөж чадаагүй тохиолдолд Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлэх;

26.1.2.Засгийн газрын гишүүнийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тус тус заасны дагуу Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулсны үндсэн дээр томилох, чөлөөлөх, огцруулах;

26.1.3.хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн Засгийн газрын дотоод, гадаад үйл ажиллагааг удирдах;

26.1.4.Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын үйл ажиллагааг чиглүүлж удирдах;

26.1.5.Засгийн газрын үйл ажиллагааны тухай Улсын Их Хурлын чуулганд мэдээлж, авах арга хэмжээний тухай саналаа өргөн мэдүүлэх;

26.1.6.энэ хуулиар тогтоосон үндсэн хүрээнд Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлыг тодруулан хуваарилах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт нэмэлт ажил, үүрэг хариуцуулах, тэдгээрийн гүйцэтгэлд хяналт тавих

26.1.7.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж хуралдааныг товлож, даргалах;

26.1.8.дотоод, гадаад харилцаанд Засгийн газрыг төлөөлөх;

26.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

26.2.Ерөнхий сайд Засгийн газрын дотоод, гадаад бодлогын асуудлаар хэлэлцээ хийхдээ Засгийн газрын гишүүд, түүний дотор уг асуудлыг эрхэлсэн гишүүнтэй санал солилцсон буюу баримтлах бодлогоо тэдгээрт урьдчилан мэдэгдэнэ.

26.3.Ерөнхий сайд энэ хуулийн 23.8 дахь хэсэгт заасан Монгол Улсын сайд нарын эрхлэх асуудлыг нэгээс нөгөөд шилжүүлэх, нэг орон тоонд нэгтгэх, шинэ орон тоонд тусгаарлан хариуцуулах зэрэг өөрчлөлт оруулах бол энэ тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлсний үндсэн дээр гүйцэтгэнэ.

26.4.Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулахдаа захирамж гаргана.

## **27 дугаар зүйл.Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

27.1.Засгийн газрын гишүүн энэ хууль болон бусад хууль тогтоомжоор олгосон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.эрхэлсэн асуудлын хүрээнд төрийн бодлого боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын хөгжил,

ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайдын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээх;

27.1.2.эрхэлсэн асуудлын хүрээн дэх яам болон энэ хуулийн 20.1 дэх хэсэгт заасан байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;

27.1.3.Засгийн газрын хуралдаанд тогтмол оролцон санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

27.1.4.хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, дүрмийг батлах, удирдлагыг томилох, чөлөөлөх;

27.1.5.эрхэлсэн асуудлаараа Улсын Их Хурлын Байнгын хороод, бусад бүтцийн нэгжтэй шууд харилцаж, Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын байр суурийг илэрхийлэх;

27.1.6.хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, хуулийн этгээдэд хянан шалгаж, биелэлтийг нь бүрэн хангуулах талаар шуурхай үүрэг даалгавар өгч, арга хэмжээ авах;

27.1.7.эрхэлсэн асуудлаараа өөрийн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрыг төлөөлж аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч холбогдох албан тушаалтантай хүлээгдэлгүй уулзах;

27.1.8.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

27.2.Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

27.3.Шийдвэрлэх асуудал нь бусад сайдын эрхлэх асуудалтай хүрээнийхтэй холбоотой бол Засгийн газрын холбогдох гишүүдтэй урьдчилан тохиролцож зохицуулна.

27.4.Засгийн газрын гишүүд хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ хүрээнд хамтарсан тушаал гаргаж болно.

27.5.Тодорхой бодлогын асуудлаар гарсан саналын зөрүүг Засгийн газрын гишүүд өөрсдөө зохицуулж чадаагүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ.

27.6.Засгийн газрын гишүүн нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх, төрийн зүтгэлтний ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, төрийн болон албаны нууцыг хадгалах үүрэгтэй.

27.7.Засгийн газрын гишүүн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ

чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.” хэмээн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

27.8.Засгийн газрын гишүүн тангараг өргөх журмыг Улсын Их Хурал тогтооно.

27.9.Засгийн газрын гишүүн шийдвэр, мэдэгдэл гаргах, аливаа хэлбэрээр албан ёсны байр сууриа илэрхийлэхдээ Ерөнхий сайдын бодлогыг баримтална.

27.10.Засгийн газрын гишүүн эрхэлсэн асуудлынхаа хүрээнд Ерөнхий сайдын бодлогыг зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай гэж үзвэл энэ тухай зохих шийдвэрийн төсөл бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

27.11.Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэсэн хуулийн төсөл, төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүний хувьд зарчмын өөр санал илэрхийлэхийг хориглоно.

27.12.Засгийн газрын гишүүн хууль тогтоомжоор эрх олгоогүй, түүнчлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээгүй буюу хэлэлцсэн боловч олонхын дэмжлэг аваагүй асуудлаар Засгийн газрыг төлөөлөх эрхгүй.

27.13.Засгийн газрын гишүүн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргийг бие даан хэрэгжүүлж, түүний үр дагаврыг хариуцна.

27.14.Засгийн газрын гишүүн нэг хоногоос дээш хугацаагаар орон нутагт болон гадаадад зорчих тохиолдолд Ерөнхий сайдаас зөвшөөрөл авах бөгөөд очих, холбоо барих хаягаа мэдэгдэнэ.

27.15.Засгийн газрын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар тогтоосон болон Ерөнхий сайдаас хуваарилан хариуцуулсан үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил хавсарч болохгүй.

27.16.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар зөвшөөрснөөс бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.

## **28 дугаар зүйл.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа**

28.1.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төр, төрийн бус байгууллага, хуулийн этгээд, тэдгээрийн албан тушаалтан, иргэд туслалцаа үзүүлэх, гаргасан хууль ёсны шийдвэр, шуурхай үүрэг чиглэлийг нь биелүүлэх үүрэгтэй.

28.2.Ерөнхий сайд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

28.2.1.түүний бие, нэр төр, уналга, зориулалтын орон сууц халдашгүй дархан байх;



28.2.2.нийслэл болон түүний орчмын газарт өвөл, зуны зориулалтын орон сууцаар хангагдах;

28.2.3.албан ёсны болон ажлын айлчлал, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээ, зориулалтын өвөл, зуны орон сууцны зардал, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлэх;

28.2.4.тусгай зориулалтын уналга болон холбоогоор хангагдах;

28.2.5.Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, уналгад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглох;

28.2.6.амь бие, орон сууц, уналга, холбооны хэрэгсэл нь улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авах;

28.2.7.эрүүл мэндийг нь онцлон хамгаалах;

28.2.8.бүрэн эрх нь дууссанаас эхлэн 2 жилийн хугацаанд төрийн тусгай хамгаалалтад байлгаж суудлын автомашин, холбоогоор хангах, бөгөөд энэ талаар тусгайлан шийдвэр гаргахгүй.

28.3.Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

28.3.1.уналга, холбооны хэрэгслээр хангагдах;

28.3.2.цалин, зайлшгүй шаардлагатай бусад хангамж авах буюу эдлэх;

28.3.3.гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба, дархан эрх эдлэх;

28.3.4.гэмт хэрэг үйлдэж огцорсноос бусад үндэслэлээр бүрэн эрхийн нь хугацаа дуусгавар болоход түүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдохоос өмнөх ажилд нь эргүүлэн ажиллуулах, тийм боломжгүй бол тухайн жилд амьдралын түвшинг нь бууруулахгүй байх арга хэмжээг Улсын Их Хурал авах.

28.4.Засгийн газрын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Ерөнхий сайдад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

28.5.Энэ хуулийн 28.4-т зааснаас бусад тохиолдолд Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр орон, уналга, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

28.6.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд татвараас бусад улс, орон нутгийн албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

28.7.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

28.8.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний цалин, жилийн зардлын хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

28.9.Хуулиар өөр баталгаа тогтоож болно.

**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**ЗАСГИЙН ГАЗРААС УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, БУСАД**  
**БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ**

**29 дүгээр зүйл.Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах**

29.1.Засгийн газар Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино.

29.2.Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, төсөв тэдгээрийн зүйл, хэсэг, заалтын талаарх өөрийн байр суурь болон Улсын Их Хурлаас дэмжлэг хүсэж байгаа асуудлыг тодорхой илэрхийлсэн байна.

29.3.Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайд огцорно.

29.4.Улсын Их Хурал Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолыг баталсан бол энэ хуулийн 29.2 дахь хэсэгт заасан асуудлыг дэмжсэнд тооцно.

29.5.Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэх асуудлыг 6 сарын дотор дахин санаачлахгүй.

29.6.Улсын Их Хурал өөрт нь итгэл хүлээлгэж байгааг нотолсон болон огцрох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол энэ тухай шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Засгийн газар уг асуудлыг өөрөө санаачлан авч хэлэлцэхгүй.

29.7.Засгийн газраас Улсын Их Хуралтай өдөр тутам шууд харилцах асуудлыг Ерөнхий сайд, эсхүл тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн эрхэлнэ.

29.8.Засгийн газар Улсын Их Хуралд жил бүр үйл ажиллагааныхаа тайланг тавьж, цаг үеийн асуудлаар тогтмол мэдээлэл хийж байна.

29.9.Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ.

29.10.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжил, төрийн удирдлагын хүрээний асуудлаар хийж гүйцэтгэх ажлын гол зорилт, хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлно.

29.11.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөгжлийн бодлого, зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, тухайн жилд хэрэгжүүлэх эдийн засаг, нийгмийн томоохон арга хэмжээ, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн уялдаа, хөрөнгийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх яам, байгууллагыг тусгана.

29.12.Засгийн газар хуулийн төсөл, төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлынхаас өөр саналтай байгаа бол Ерөнхий сайд уг саналаа дахин хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд тавьж болох бөгөөд түүнийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж хариу өгнө.

29.13.Засгийн газар хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хууль тогтоомжийн төслийг Ерөнхий сайд, түүний даалгавраар Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын даргад зохих журмын дагуу өргөн мэдүүлнэ.

29.14.Энэ хуулийн 29.13-т заасан төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийн өмнө хууль зүй, санхүү, төсвийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний албан ёсны зөвшөөрлийг авсан байна.

29.15.Ерөнхий сайд нь Улсын Их Хурлын гишүүний асуулгын хариуг хууль тогтоомжид заасан журмын дагуу өгөх үүрэгтэй.

### **30 дугаар зүйл.Засгийн газраас Ерөнхийлөгчтэй харилцах**

30.1.Засгийн газар Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг биелүүлэх арга хэмжээ авч, энэ талаар Ерөнхийлөгчид мэдээлж байна.

30.2.Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр товлосон асуудлаа Ерөнхийлөгчид тухай бүр урьдчилан мэдэгдэнэ.

30.3.Ерөнхийлөгч Засгийн газрын хуралдаанд тааллаараа оролцож, саналаа илэрхийлж болох бөгөөд хэрэв өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх бол энэ тухай зарлигийн төслийг Ерөнхий сайдад хүргүүлнэ.

30.4.Ерөнхий сайд энэ хуулийн 30.3-т заасан зарлигийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж хариу өгнө.

30.5.Ерөнхий сайд зарлигийн төслийг дэмжсэн бол Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасны дагуу гарын үсэг зурж баталгаажуулна.

30.6.Ерөнхий сайд энэ хуулийн 30.3-т заасан зарлигийн төсөлд тодорхойлсон заалтыг Засгийн газар хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл энэ тухай үндэслэлээ Ерөнхийлөгчид уламжилна.

### **31 дүгээр зүйл.Засгийн газраас бусад байгууллагатай харилцах**

31.1.Засгийн газар нь өөрийн бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслийн төлөөллийн төв байгууллагатай шууд, Улсын Их Хуралд суудалгүй нам, бусад төрийн бус байгууллагатай төрийн захиргааны зохих төв байгууллагаар уламжлан, бусад байгууллагатай төрийн

захиргааны төв болон нутгийн захиргааны зохих шатны байгууллагаар дамжуулан харилцана.

31.2.Улсын хэмжээний зохион байгуулалтын бүтэц бүхий төрийн бус байгууллага нь өөрийн үйл ажиллагааны талаарх асуудлаар удирдах байгууллагаараа уламжлан Засгийн газартай харилцана.

31.3.Засгийн газар нь төрийн бус байгууллагаас улс орныг хөгжүүлэх, төр, нийгмийн байгууллыг бэхжүүлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангахад тус дөхөм үзүүлэх талаар гаргасан санал, санаачилгыг дэмжих шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тэдгээр байгууллагатай харилцан ажиллана.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗРЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **32 дугаар зүйл.Засгийн газрын хуралдаан**

32.1.Засгийн газар энэ хууль, бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ асуудал, түүнчлэн Улсын Их Хурлаас даалгасан, Ерөнхийлөгчөөс санал болгосон асуудлыг хуралдаанаараа хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ.

32.2.Засгийн газар доор дурдсан асуудлыг хуралдаанаараа заавал хэлэлцэнэ:

32.2.1.хуулийн төсөл;

32.2.2.хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл;

32.2.3.Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн төсөл;

32.2.4.Засгийн газрын бодлогод өөрчлөлт оруулахаар Засгийн газрын гишүүнээс ирүүлсэн санал /төсөл/;

32.2.5.Ерөнхий сайд дангаар шийдвэрлээгүй болон Засгийн газрын гишүүдээс эрхлэх асуудлаараа өөрсдөө тохиролцож чадаагүй саналын зөрөөг шийдвэрлэх асуудал.

32.3.Засгийн газрын хуралдаанд бэлтгэх, асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ дараахь журмыг баримтална:

32.3.1.хуралдааныг Ерөнхий сайдын товлосноор, эсхүл Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал болговол хуралдааныг хийх;

32.3.2.хуралдааныг энэ хуулийн 29.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд нийт гишүүний гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцох;

32.3.3.Засгийн газраас санаачлах хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20.7-20.9 заасны дагуу холбогдох Засгийн газрын гишүүний зөвшөөрлийг авсны үндсэн дээр хариуцсан Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;

32.3.4.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хуулийн төслийн талаарх Засгийн газрын санал, дүгнэлтийн төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн бэлтгэж, хуралдаанд хэлэлцүүлэх;

32.3.5.хэлэлцэх асуудлыг Засгийн газрын гишүүн эрх хэмжээний дотор санаачлан хэлэлцүүлэх;

32.3.6.бусад байгууллага, албан тушаалтан, иргэд хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын тухай саналаа Засгийн газрын холбогдох гишүүнээр уламжлан тавих;

32.3.7.хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөл, түүний үндэслэлийг Засгийн газрын хариуцах гишүүн, хэрэв хэд хэдэн гишүүн хариуцах бол тэдгээр нь хянан үзээд бэлтгэл хангагдсан гэж үзвэл хуралдаанд оруулах;

32.3.8.шийдвэрийн төслийг хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлигт нийцүүлэн гүйцэд боловсруулж, зохих тооцоо, судалгаа, холбогдох Засгийн газрын гишүүний зөвшөөрлөөр нотолсон байх;

32.3.9.хариуцсан гишүүний зөвшөөрсөн төсөл, түүний үндэслэлийг Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдад танилцуулж, түүний зөвшөөрснөөр нийт гишүүнд уг асуудлыг хэлэлцэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө гардуулах;

32.3.10.асуудлыг Ерөнхий сайдаас тогтоосон дарааллын дагуу хэлэлцэх.

32.4.Засгийн газрын хуралдааны нарийвчилсан дэгийг энэ хуулийн дагуу Засгийн газар тогтооно.

32.5.Хуралдааныг Ерөнхий сайдын шийдвэрлэснээр нээлттэй, хаалттай, цахим болон өргөтгөсөн хэлбэрээр явуулж болох бөгөөд хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

32.6.Засгийн газрын хуралдааныг Засгийн газрын хуралдааны танхимд, эсхүл зохих шаардлагыг хангасны үндсэн дээр Ерөнхий сайдын тогтоосон газарт хуралдуулна.

### **33 дугаар зүйл.Засгийн газрын шийдвэр**

33.1.Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана.

33.2.Засгийн газар асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол шийдвэр гараагүйд тооцно.

33.3.Засгийн газар хуулиар тусгайлан эрх олгосон тохиолдолд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд захиргааны хэм хэмжээний акт гаргаж болох бөгөөд тогтоол хэлбэртэй байна.

33.4.Засгийн газар захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа тусгайлан эрх олгосон хуулийг үндэслэл болгоно.

33.5.Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн шийдвэрийн төслийг тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан Засгийн газрын гишүүн хянан үзэж ёсчлон гаргах зөвшөөрөл өгнө.

33.6.Засгийн газрын тогтоолд түүний биелэлтийг хариуцсан сайд нар, дараа нь Ерөнхий сайд гарын үсэг зурна.

33.7.Засгийн газрын шийдвэрт Ерөнхий сайд гарын үсэг зурахын өмнө тухайн шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нотолсон байвал зохино.

33.8.Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж нь тэдгээрт болон хуульд өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

33.9.Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

33.10.Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах аргачлалыг Засгийн газар батална.

#### **34 дүгээр зүйл.Засгийн газрын шийдвэрийг нийтлэх**

34.1.Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрт Ерөнхий сайд гарын үсэг зурснаас хойш ажлын 3 хоногийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвшөөрснөөр Ерөнхий сайдын ажлын албанаас эрхлэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

34.2.Засгийн газар тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрийн заалтыг хариуцан гүйцэтгэх байгууллагад хүргүүлж, биелэлтийг нь хянан шалгаж, зохион байгуулан үр дүнг хугацаанд нь тооцно.

#### **35 дугаар зүйл.Засгийн газрын хуралдааны явцыг баримтжуулах, тэдгээрийг ашиглах, хадгалах**

35.1.Засгийн газрын хуралдааны явцыг баримтжуулах /гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичиж албан ёсны тэмдэглэл хөтлөх/ ажлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эрхэлнэ.

35.2.Засгийн газрын хуралдааны явцын тэмдэглэлд хуралдаанд оролцсон гишүүд, тухайн асуудал бүр дээр тэдгээрийн гаргасан санал, шүүмжлэл, түүнчлэн санал хураалтын дүнг заавал тусгаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гарын үсэг зурна.

35.3.Засгийн газрын хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон болон цахим бичлэгийг ашиглах, архивт хадгалах журмыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тогтооно.

#### **36 дугаар зүйл.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын чиг үүрэг**

36.1.Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын

харилцан ажиллагааг зохицуулахад туслах, хүний нөөцийн удирдлага, нийтлэг үйлчилгээний удирдлагаар хангах асуудлыг эрхлэн гүйцэтгэж, дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

36.1.1.Засгийн газрын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, энэ талаар яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг зохицуулах;

36.1.2.Засгийн газрын стратегийн удирдлага, төлөвлөлт санхүүгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

36.1.3.төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж, үүнтэй холбогдсон тэргүүний арга барилыг нэвтрүүлэх;

36.1.4.нийтлэг үйлчилгээний бодлогыг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шаардлагатай зөвлөлгөө, удирдлага, зохицуулалтаар хангах;

36.1.5.Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийг шаардлагатай зөвлөлгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах;

36.1.6.танхимын хуралдаанд хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг зохих журмын дагуу бэлтгэж хуралдаанд оруулах;

36.1.7.танхимын хуралдааны зохион байгуулалт, техникийн бэлтгэлийг хангах;

36.1.8.Засгийн газрын шийдвэрийг хэлбэржүүлэн гаргаж нийтэлж мэдээлэх;

36.1.9.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг нэгтгэн хуралдаанд танилцуулах;

36.1.10.танхимын хуралдааны явцын тэмдэглэл, Засгийн газарт орж гарах бичиг хэргийн ажиллагааг эрхэлж зохион байгуулах;

36.1.11.Засгийн газарт иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

36.1.12.хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах.

36.2.Хэрэг эрхлэх газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар батална.

36.3.Засгийн газар шаардлагатай бол зөвлөл, ажлын бусад албыг байгуулж зардлынхаа төсөвт багтаан ажиллуулж болно.

## **37 дугаар зүйл.Ерөнхий сайдын ажлын алба**

37.1.Ерөнхий сайд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ зөвлөгөө авах, шуурхай ажлын зохион байгуулалтыг хангах үүрэг бүхий ажлын албатай байна.

37.2.Ерөнхий сайдын ажлын албаны орон тооны хязгаар, зардлын төсвийг Засгийн газар тогтооно.

37.3.Ерөнхий сайдын зөвлөх, ажлын албаны ажилтан Ерөнхий сайдад ажлаа шууд хариуцаж, Хэрэг эрхлэх газарт харьяалагдана.

### **38 дугаар зүйл.Шадар сайдын ажлын алба**

38.1.Шадар сайд ажлын албатай байна.

38.2.Шадар сайдын ажлын албаны орон тооны хязгаар, зардлын төсвийг Засгийн газар тогтооно.

38.3.Ажлын албаны ажилтан ажлаа Шадар сайдын өмнө хариуцаж, Хэрэг эрхлэх газарт харьяалагдана.

### **39 дүгээр зүйл.Засгийн газрын болон төрийн захиргааны байгууллагад улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглох**

39.1.Засгийн газрын болон төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллагад аливаа улс төрийн үйл ажиллагааг явуулахыг хориглоно.

### **40 дүгээр зүйл.Засгийн газрын тамга, тэмдэг, бэлгэдэл**

40.1.Засгийн газар соёмбо бүхий тамга, тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

40.2.Засгийн газрын тамга, тэмдэг хийх, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

40.3.Засгийн газар албан ёсны бэлгэдэлтэй байх бөгөөд “Засгийн газар” гэсэн нэршил, бэлгэдлийг иргэн, хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно.

---o0o---